

“ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 04 сарын 27 өдөр

Цогтцэций сум

“Тавантолгой” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 10:00 цагт Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Цагаан-овоо 3 дугаар баг, “Тавантолгой” ХК-ийн төв оффисын 2 давхрын хурлын танхимд эхлэв.

Хурлын ирц: Хурлын дэгийн дагуу 11:00 цаг хүртэл ирц бүртгэсэн.

Тооллогын комиссын дарга С.Дөлгөөны танилцуулснаар:

Компанийн 50,219,868 ширхэг хувьцааг эзэмшиж буй 19 хувьцаа эзэмшигч хуралд оролцож байгаа нь нийт саналын эрхтэй 52,665,200 ширхэг энгийн хувьцааны 95.36% болж байна. Иймд “Компанийн тухай” хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2 дахь хэсгийг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов.

Хурлын дарга Б.Мэндбаяр хурлын хэлэлцэх асуудлуудыг танилцуулав. Үүнд:

1. “Тавантолгой” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах тухай
2. “Тавантолгой” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай
3. “Тавантолгой” ХК-ийн 2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай
4. “Тавантолгой” ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилсан тухай тайланг танилцуулах тухай
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгох тухай
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсөв батлах тухай

Мөн хурлын зохион байгуулалт, хувьцаа эзэмшигчдийг төлөөлөн хуралд оролцож буй оролцогчдыг танилцуулав.

Хэлэлцсэн нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах тухай

“Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ш.Отгонбаяр компанийн 2025 оны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнгийн талаар танилцуулгыг хувьцаа эзэмшигчид болон тэдний төлөөлөлд танилцуулав. Тайланг танилцуулж, асууж тодруулах зүйл байвал нээлттэй хандахыг хүсэв.

2. “Тавантолгой” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

“Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн дарга Б.Мэндбаяр компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн “Хангалттай” дүгнэлтийг хуралд танилцуулж, хурлаас гарах шийдвэрийн төслийг уншиж танилцуулав.

3. “Тавантолгой” ХК-ийн 2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай

“Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн дарга Б.Мэндбаяр компанийн 2025 оны жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг хуралд танилцуулж, холбогдох тогтоолын төслийг уншиж танилцуулав.

4. “Тавантолгой” ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилсан тухай тайланг танилцуулах тухай

“Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ш.Отгонбаяр компанийн 2024 оны жилийн цэвэр ашгаас ногдол ашиг тараасан тайланг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав. Хурлын дарга Б.Мэндбаяр хурлаас гарах шийдвэрийн төслийг уншиж танилцуулав.

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай

“Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн дарга Б.Мэндбаяр Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 үйл ажиллагааны тайланг хуралд дэлгэрэнгүй танилцуулж, хувьцаа эзэмшигчдийг ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангав. Мөн хэлэлцэх асуудалтай холбоотой хурлаас гарах шийдвэрийн төслийг уншиж танилцуулав.

6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгох тухай

“Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн дарга Б.Мэндбаяр компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг дахин сонгохтой холбоотойгоор ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны саналын дагуу хурлаар хэлэлцэхээр оруулсан нэр дэвшигчдийг танилцуулж, мэдээлэл хүргэв. Нэр дэвшигчдийн мэдээлэл:

Ердийн гишүүнд нэр дэвшигч:

1. Б.Мэндбаяр
2. Э.Бөхбат
3. Ё.Номинтунгалаг
4. Д.Бат-Эрдэнэ
5. С.Мятавдорж
6. Ц.Цэнгэлбаяр

Хараат бус гишүүнд нэр дэвшигч:

1. Ч.Отгонбаяр
2. Б.Батсүрэн
3. Д.Дэлгэрцогт

7. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсөв батлах тухай

“Тавантолгой” ХК-ийн хурлын дарга Б.Мэндбаяр төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсөв төлөвлөгөөг дэлгэрэнгүй танилцуулж, батлуулах тухай хэлэлцэв.

Асуулт, санал: Хурлаар хэлэлцүүлэх асуудлуудыг танилцуулж дууссаны дараа хурлын дэгийн дагуу хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асуух, санал хэлэх хугацааг эхлүүлэв. Хувьцаа эзэмшигчдийн зүгээс аливаа асуулт, санал байгаагүй тул хурлыг цааш үргэлжлүүлэв.

Санал хураалт: Хурлын дэгийн дагуу тооллогын комиссын дарга С.Дөлгөөн санал хураалт эхэлж буйг мэдэгдэж, хэлэлцэж байгаа нийт 7 асуудлын нэг асуудалд нь ердийн аргаар, 1 асуудал буюу ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудалд кумулятив аргаар санал хураахыг дурдаж, саналын хуудсыг бөглөх аргачлалыг товч танилцуулав.

Санал хураалт явагдаж дуусав.

Тооллогын комиссын дарга С.Дөлгөөн санал хураалтын дүнг танилцуулав.

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. “Тавантолгой” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах тухай

Зөвшөөрсөн - 50,219,868 ширхэг хувьцаа буюу 100%

Татгалзсан - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн - 0 ширхэг хувьцаа буюу 0%

2. “Тавантолгой” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах

Зөвшөөрсөн - 50,219,868 ширхэг хувьцаа буюу 100%

Татгалзсан - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн - 0 ширхэг хувьцаа буюу 0%

3. “Тавантолгой” ХК-ийн 2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай

Зөвшөөрсөн – 50,219,868 ширхэг хувьцаа буюу 100%

Татгалзсан - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн - 0 ширхэг хувьцаа буюу 0%

4. “Тавантолгой” ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилсан тухай тайланг танилцуулах

Зөвшөөрсөн - 50,219,868 ширхэг хувьцаа буюу 100%

Татгалзсан - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн - 0 ширхэг хувьцаа буюу 0%

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайланг танилцуулах

Зөвшөөрсөн - 50,219,868 ширхэг хувьцаа буюу 100%

Татгалзсан - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн - 0 ширхэг хувьцаа буюу 0%

6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсөв батлах тухай

Зөвшөөрсөн - 50,219,868 ширхэг хувьцаа буюу 100%

Татгалзсан - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Хурлаар дараах асуудлыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг шинээр сонгох тухай

Саналын хуудсаар “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай асуудлаар хуралд оролцсон саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналын дүн:

Ердийн гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Бямбаагийн Мэндбаяр	6.059%	27,384,027
2	Эрдэнэчулууны Бөхбат	6.058%	27,380,982
3	Ёндонгийн Номинтунгалаг	6.054%	27,360,939
4	Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ	18.109%	81,849,822
5	Сүрэнхүүгийн Мятавдорж	18.120%	81,896,671
6	Цэнд-Аюушийн Цэнгэлбаяр	23.162%	104,688,354

Хараат бус гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Чинзоригийн Отгонбаяр	6.058%	27,380,983
2	Батцэцэгийн Батсүрэн	6.054%	27,360,939
3	Даваадоржийн Дэлгэрцогт	10.327%	46,676,095

тус тус санал авч эдгээр гишүүд ТУЗ-ийн гишүүдэд сонгогдов.

Хурлын шийдвэр:

1. “Тавантолгой” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах тухай

1. “Тавантолгой” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн дэлгэрэнгүй тайланг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй.

2. “Тавантолгой” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад зохих мэдээллийг Хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд журмын дагуу хүргэж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

2. “Тавантолгой” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 16, 17 дугаар тогтоолоор батлагдсан “Тавантолгой” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг баталсугай.

2. Хуралд танилцуулсан дүгнэлтийг цаашид бодлого, шийдвэртээ тусгаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

3. “Тавантолгой” ХК-ийн ХК-ийн 2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах

1. “Тавантолгой” ХК-ийн 2025 оны жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 07 дугаар тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй.

2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийн дагуу ногдол ашиг хуваарилах, Хувьцаа эзэмшигчдэд бүрэн олгох ажлыг зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

4. “Тавантолгой” ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах

1.“Тавантолгой” ХК-ийн 2024 оны жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахтай холбоотойгоор 2025 оны тайлант жилд гүйцэтгэсэн ногдол ашиг тараах үйл ажиллагааны тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй.

2.Ногдол ашиг хуваарилан олгосон тухай мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Хувьцаа эзэмшигчид, олон нийтэд мэдээлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайланг танилцуулах

1.“Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй.

2.“Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлант жилийн хугацаанд гүйцэтгэсэн үйл ажиллагааг ХАНГАЛТТАЙ гэж дүгнэсүгэй.

6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгох тухай

1.“Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн, хараат бус гишүүдийг Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналыг кумулятив аргаар тоолж нэгтгэсэн дүнд үндэслэн дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай. Үүнд:

1.1. Б.Мэндбаяр	/ердийн гишүүн/
1.2. Э.Бөхбат	/ердийн гишүүн/
1.3. Ё.Номинтунгалаг	/ердийн гишүүн/
1.4. Д.Бат-Эрдэнэ	/ердийн гишүүн/
1.5. С.Мятавдорж	/ердийн гишүүн/
1.6. Ц.Цэнгэлбаяр	/ердийн гишүүн/
1.7. Ч.Отгонбаяр	/хараат бус гишүүн/
1.8. Б.Батсүрэн	/хараат бус гишүүн/
1.9. Д.Дэлгэрцогт	/хараат бус гишүүн/

2.Шинээр сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг холбогдох хууль тогтоомжид заасан эрх, үүргийн хүрээнд идэвх санаачилгатай ажиллахыг үүрэг болгосугай.

7. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны төсөв батлах тухай

1.“Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2025 оны үйл ажиллагааны үр дүнгийн урамшууллын хэмжээг нэгдүгээр, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөх цалингийн хэмжээг хоёрдугаар, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төсвийг гуравдугаар хавсралтаар баталсугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Цалин урамшууллын хороо, Төлөөлөн удирдах зөвлөлийн төсөвт тусгагдсан зардлыг санхүүжүүлж ажиллахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

Хурлын дарга хурлыг хааж үг хэлснээр хурал 14:13 минутад дуусав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

/Б.БӨХБАТ/

ТЭМДЭГЛЭЛ ХЯНАСАН:

/Б.МЭНДБАЯР/
ХУРАЛ ДАРГАЛАГЧ